

Үндэсний хөгжлийн газрын даргын  
2020 оны 11 сарын 18 өдрийн 11/18-тоот  
тушаалын ..... хавсралт

## ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /цаашид УХОХ/-ийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, түүнд тусгах эдийн засгийн үр ашгийн шинжилгээг хийхэд энэхүү аргачлалын зорилго оршино.
- 1.2. Энэхүү аргачлалын үр дүн нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээг (цаашид төсөл гэх) үнэлэх, эрэмбэлэх, сонгоход ашиглагдана.
- 1.3. УХОХ-т тусгах төслүүдийн санхүүгийн өгөөж, үр ашиг хангалтгүй байж болох ч эдийн засгийн үр ашигтай, улс орон, нийгэм, төслийн үр шимийг хүртэгчдийн сайн сайхан байдалд үзүүлэх нийгмийн үр өгөөж, ач холбогдол өндөртэй байх шаардлагатай гэж үзнэ.

### ХОЁР. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - *Эдийн засгийн шинжилгээ (Economic analysis)* - Улс, бүс, орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулах төслийн хувь нэмэр буюу тухайн төслөөс бий болох ашиг/алдагдлын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох зорилготой шинжилгээ;
  - *Эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ (Economic impact analysis - EIA)* – Мера төслүүдийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох шинжилгээ;
  - *Олон шинжүүрт шийдвэрийн шинжилгээ (multi-criteria decision analysis-MCDA)*- Эрсдлийн шинжилгээ, үнэлгээ, тодорхойгүй байдал болон шийдвэр гаргахад шаардлагатай бусад шалгууруудыг тогтоож, олон санааг үнэлэх, эрэмбэлэх зорилгоор ашигладаг арга;
  - *Сүүдрийн үр ашиг* (эдийн засгийн үр ашиг) - Эдийн засгийн шууд болон шууд бус бүх нөлөөллийг хамруулан тооцсон үр ашгийн хэмжүүр юм.
  - *Хилийн үнэ (border price)* – Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт, импортын хилийн боомт дахь үнэ;
  - *Стандарт шилжүүлгийн фактор (standard conversion factor-SCF)* – Дотоодын зах зээлийн үнийн дүнгээр илэрхийлэгдсэн төслийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг эдийн засгийн нөлөө бүхий хилийн үнэ буюу эдийн засгийн үнэ болгон хөрвүүлэгч коэффициент;
  - *Салбарын тусгай шилжүүлгийн фактор (sector conversion factor-CF)* - Орц болон гарц нь зөвхөн дотоодод арилжаалагддаг бүтээгдэхүүн үйлчилгээг хилийн үнэ рүү хөрвүүлэгч.
  - *Нийгмийн хорогдуулалтын хувь (social discount rate-SDR)* – Төслийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тодорхойлоход ашигладаг хорогдуулалтын хувь. Энэ нь төслийн бий болгож байгаа үр ашиг нь ирээдүйд нийгэмд хэрхэн нөлөөлөх, өнөөгийн байдлаас хэрхэн өөрчлөхийг илэрхийлэхэд ашиглагдана. Өөрөөр хэлбэл, энэ нь төслүүдийн санхүүгийн үр дүнг нийт эдийн засагт үзүүлэх үр өгөөж рүү хөрвүүлэн тооцоход ашиглагдах үзүүлэлт юм.

- Эдийн засгийн өгөөжийн домоод хувь (*economic internal rate of return-EIRR*) – Төслийн эдийн засгийн үр өгөөжийн индекс;
- Эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (*ENPV*) - Төслийн нийт эдийн засгийн хорогдуулсан өгөөж болон түүнийг бий болгоход гаргасан нийт эдийн засгийн хорогдуулсан зардлын зөрүү;
- Сүүдрийн цалингийн түвшин (*Shadow wage-SWR*)- Макро эдийн засгийн тэнцвэргүй байдлаас үүссэн хөдөлмөрийн хөлсний гажуудал;

### **ГУРАВ. ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫГ ТООЦОХ АРГУУД**

- 3.1. УХОХ-т тусгах төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцохдоо төслийн шинжилгээний дараах 3 аргыг ашиглана. Үүнд:
  - *Зардал-үр ашгийн шинжилгээ* - Мөнгөн дүнд суурилсан, үр ашгийг бий болгохтой холбогдон гарсан зардлыг үр ашгийн мөнгөн дүнтэй харьцуулдаг арга бөгөөд зардал, орлого, үр ашгийг нь бүрэн үнэлж тооцох боломжтой төслүүдийг үнэлж, эрэмбэлэхэд ашиглагдана;
  - *Зардал-үр өгөөжийн шинжилгээ* - Төслийн гарц, үр дүн нь мөнгөн дүнгээр хэмжигдэхгүй, мөнгөн бус хэлбэр буюу бодит нэгжээр илэрхийлэгдэх бол орц нь мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх төслүүдийг үнэлж, эрэмбэлэхэд ашиглагдана;
  - *Хамгийн бага зардлын шинжилгээ* - Төслийн үр нөлөө нь ижил тэнцүү хэд хэдэн төслүүдийг зардлаар нь харьцуулж эрэмбэлэн, хамгийн бага зардалтай төслийг сонгоход ашиглагдана.
- 3.2. Хөрөнгө оруулалтын нийгмийн үнэ цэнийг тодорхойлох, өөрөөр хэлбэл орц, гарцын нийгмийн алдагдсан боломжийн өртгийг бодитойгоор илэрхийлэх нь зардал - үр ашгийн шинжилгээний зорилго юм.
- 3.3. Зардал - үр ашгийн шинжилгээ нь Төслийн товч танилцуулга, Төслийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт; Хэрэгжих боломжийн болон хувилбарын шинжилгээ; Санхүүгийн шинжилгээ; Эдийн засгийн шинжилгээ; Эрсдэлийн шинжилгээ гэсэн үндсэн хэсгүүдтэй байна.
- 3.4. УХОХ-т тусгах төслийн зардал – үр ашгийн шинжилгээ хийхдээ Үндэсний хөгжлийн газрын даргын А-56 тоот тушаалын Хавсралт 4-н дагуу Санхүүгийн шинжилгээг, Хавсралт 3-н дагуу Эрсдэлийн шинжилгээг, энэхүү аргачлалаар Эдийн засгийн шинжилгээг, хэрэв тухайн төсөл нь үйлдвэрлэлийн төсөл бол уг тушаалын Хавсралт 6-н дагуу Хувилбаруудын технологиин түвшний үнэлгээг тус тус хийнэ.
- 3.5. ~~Хэрэв зардал~~ – үр ашгийн шинжилгээ хийж буй төслийн санхүүгийн мөнгөн орлогыг тооцох боломжгүй (хураамжгүй зам, төлбөргүй сургууль г.м.) бол санхүүгийн шинжилгээг хийлгүй зөвхөн эдийн засгийн шинжилгээ хийнэ.
- 3.6. Зарим тохиолдолд зардал-үр өгөөжийн шинжилгээ (*cost-effectiveness analysis – CEA*) нь ижил төстэй үр дүнтэй төслүүдийг харьцуулахад үр дүнтэй байдаг боловч зардал-үр ашгийн шинжилгээг (*cost-benefit analysis – CBA*) орлохгүй.
- 3.7. Зардал - үр өгөөжийн шинжилгээ нь хязгаарлагдмал хөрөнгө нөөцийн хэмжээнд төслийн үр шимийг хүртэгчдэд хамгийн ихээр нөлөөлөх, хамгийн өндөр үр өгөөж, ач холбогдолтой үр дүн гаргах төслийг тодорхойлоход чиглэнэ.

### **ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙГ ХИЙХ ДАРААЛАЛ, ҮЕ ШАТ**

- 4.1 Эдийн засгийн шинжилгээ нь зардал – үр ашгийн шинжилгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төслийн улс, бүс, орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэхэд чиглэсэн шинжилгээ юм.

4.2 Эдийн засгийн шинжилгээний үе шат нь санхүүгийн шинжилгээний үе шаттай адил боловч зарим зардал, үр ашгийн үнэлгээ, шинжилгээний үзүүлэлтүүд нь өөр байна.

4.2.1 **Үе шат 1. Санхүүгийн зардлыг эдийн засгийн зардал шилжүүлэх стандарт шилжүүлгийн факторыг тодорхойлох.** Стандарт шилжүүлгийн факторыг (SCF) экспорт, импортын үнэ дээр суурилж дараах томъёогоор тооцох ба Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тодорхойлж, үечилсэн байдлаар шинэчилнэ. Хөрвүүлэгчийн утга 1-ээс бага байх ёстой.

$$SCF = \frac{M+X}{[(M+Mt)+(X+Xt)]}$$

Энд:  $M$  – нийт импорт,  $X$  – нийт экспорт,  $Mt$  – импортын татвар,  $Xt$  – экспортын татвар

4.2.2 **Үе шат 2. Эдийн засгийн зардлыг тодорхойлох.** Эдийн засгийн зардал гэдэг нь ДНБ хорогдох хэмжээ бөгөөд ДНБ-ийн нэмэгдэх, буурахад шууд нөлөөлөхгүй зардлууд, үнийн өсөлтийн болзошгүй зардал зэрэг нь эдийн засгийн зардалд орохгүй. Нөгөөтээгүүр санхүүгийн зардалд хамаарахгүй боловч гадаад зах зээлээр дамжихгүйгээр ДНБ буурахад нөлөөлөх биет бус зардлыг эдийн засгийн зардал гэж тооцно. Жишээ нь, байгаль орчин муудсанаас үүдэн ойр орчмын газар тариалангийн ургац багассан бол багассан хэмжээг эдийн засгийн зардал гэж үзнэ.

- Санхүүгийн зардал дээр төслийн эдийн засагт үзүүлэх сөрөг дам нөлөөг арилгах зардлыг нэмнэ.
- Улсын хэмжээнд нэг этгээдээс нөгөө этгээдэд шилжих бүх орц, гарцуудын НӨАТ, татвар, хураамж, шууд бус шимтгэлүүд, ажиллагчдын цалин хөлсний дүнгээс авах бүх төрлийн татвар, хураамж зэрэг зардлыг хасна. Харин төслийн сөрөг дам нөлөөг арилгахтай холбоотой агаарын бохирдлын г.м. татвар, хураамжийг хасахгүй.
- Санхүүгийн зардлуудыг стандарт шилжүүлгийн факторыг (standard conversion factor-SCF) эсхүл салбарын тусгай шилжүүлгийн факторыг (sector conversion factor-CF) ашиглан эдийн засгийн зардалд шилжүүлнэ.
- Сүүдрийн цалин хөлсийг дараах томъёогоор тооцож зардлын тооцоололд ашиглана. Дараах төрлийн ажилгүйдлээс шалтгаалж сүүдрийн цалингийн түвшин ялгаатай байна.

а)  $SWR = W(1 - u)(1 - t)$

Энд:  $SWR$  - сүүдрийн цалингийн түвшин,  $W$  - зах зээлийн цалин,  $t$ -шинэ ажилтан ажилд авах жилийн зардал,  $c$ -хөрвүүлэгч фактор,  $z$ -ажилчдыг шилжүүлэх зардал,  $d$ -хөрвүүлэгч фактор,  $n$ -захиаалгын хөлс,  $u$ -ажилгүйдлын түвшин,  $L$ -хөдөлмөр,  $t$ -ХХОАТ болон НДШ,  $\Delta u$ -ажилгүйдлын түвшний өөрчлөлт,  $\Delta L$ -хөдөлмөрийн өөрчлөлт

б) Бүрэн ажил эрхлэлт -  $SWR = W$

в) Бага хэмжээний ажилгүйдэл -  $SWR = mc + zd$

г) Хосолсон хөдөлмөрийн зах зээл -  $SWR = n(\Delta u/\Delta L) + zd$

4.2.3 **Үе шат 3. Эдийн засгийн өгөөжийг тодорхойлох.** Эдийн засгийн өгөөж гэж ДНБ-ийг нэмэгдүүлэх зүйл, өөрөөр хэлбэл төслөөр бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг өгөх эсвэл авах үнэ цэнэ ба төслөөр хэмнэгдсэн зардлын үнэ цэнээр тооцож мөнгөн дүнд хөрвүүлсэн дүнг хэлнэ. Жишээ нь, хурдны зам барьж байгаа бол эхлээд цаг хугацааны хэмнэлтийг эдийн засгийн өгөөжийн нэг үзүүлэлт болгон тодорхойлсон

бол зорчигчийн хэмнэх боломжтой цаг, хэмнэсэн цагтаа олж болох орлогын хэмжээгээр өөрөөр хэлбэл хурдны замгүй байгаа үед зам дээр зарцуулж байгаа цаг хугацааны алдагдсан боломжийн өртгөөр цаг хугацааны үнэ цэнийг тооцоолж болно.

- Санхүүгийн орлого дээр төслийн эдийн засагт үзүүлэх эерэг дам нөлөөллөөс орох орлогыг нэмнэ.
- Төрийн байгууллагаас олгосон татаас нь цэвэр шилжүүлэг тул эдийн засгийн шинжилгээ хийхдээ орлогоос хасна.
- Санхүүгийн орлогуудыг стандарт шилжүүлгийн факторыг (standard conversion factor-SCF) эсхүл салбарын тусгай шилжүүлгийн факторыг (sector conversion factor-CF) ашиглан эдийн засгийн өгөөжид шилжүүлнэ.
- Хэрэв төсөл орлогогүй бол төлөх-сонирхлын арга (willingness to pay - WTP), урт хугацааны өөрийн өртгийн аргын (long-run marginal cost - LRMC) аль нэгийг эсхүл тэдгээрийн дунджийг ашиглан эдийн засгийн өгөөжийг тодорхойлно.
- Тухайн төслийн эдийн засгийн өгөөжийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг мөнгөжүүлнэ.

4.2.4 **Үе шат 4.** Нийгмийн хорогдуулалтын хувийг тодорхойлох. Эдийн засгийн шинжилгээнд хэрэглэгддэг нийгмийн хорогдуулалтын хувь нь (social discount rate - SDR) нийт эдийн засагт төслөөс үзүүлэх бага өгөөжийн хувь юм. Нийгмийн хорогдуулалтын хувийг дараах томъёогоор тооцох ба Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тодорхойлж, үечилсэн байдлаар шинэчилнэ.

$$SDR = e \times g + p$$

Энд:  $e$  – нийгмийн хорогдуулалтын хувь,  $g$  – төсвийн зарлагаас хамаарах нийгмийн ханамжийн уян хатан байдал,  $g$  – төсвийн зарлагын өсөлтийн хувь,  $p$  – хугацааны давуу байдлын хувь

4.2.5 **Үе шат 5.** Төслийн эдийн засгийн мөнгөн урсгалын төсөөллийг хийх. Төслийн эдийн засгийн зардал, өгөөжийн тооцоололд үндэслэн нийгмийн хорогдуулалтын хувь (SDR)-р хорогдуулсан эдийн засгийн мөнгөн урсгалын төсөөллийг хийнэ.

4.2.6 **Үе шат 6.** Эдийн засгийн үр ашгийг илэрхийлэх үзүүлэлтүүдийг тооцоолох. Төслийн эдийн засгийн үр ашгийг нийгмийн хорогдуулалтын хувь (SDR)-р хорогдуулсан мөнгөн урсгалд үндэслэн тооцсон эдийн засгийн өгөөжийн дотоод хувь (EIRR), эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (ENPV), үр ашиг зардлын харьцаа (BCR) зэрэг үзүүлэлтүүдээр дараах томъёогоор тодорхойлно.

$$ENPV = \sum_{t=1}^n \frac{(B_t - C_t)}{(1 + SDR)^t}$$

Энд: ENPV- эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэн,  $B_t$ -эдийн засгийн үр өгөөж,  $C_t$ -эдийн засгийн зардал, SDR - нийгмийн хорогдуулалтын хувь,  $t$ -хугацаа

$$ENPV = 0 = \sum_{t=1}^n \frac{B_t}{(1 + EIRR)^t} + \frac{C_t}{(1 + EIRR)^t}$$

Энд: ENPV- эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэн,  $B_t$ -эдийн засгийн үр өгөөж,  $C_t$ -эдийн засгийн зардал, EIRR-эдийн засгийн үр өгөөжийн дотоод хувь,  $t$ -хугацаа

$$BCR = \frac{\sum_{t=1}^n \frac{B_t}{(1 + SDR)^t}}{\sum_{t=1}^n \frac{C_t}{(1 + SDR)^t}}$$

Энд: BCR- Үр ашиг зардлын харьцаа,  $B_t$ -эдийн засгийн үр өгөөж,  $C_t$ -эдийн засгийн зардал, SDR - нийгмийн хорогдуулалтын хувь,  $t$ -хугацаа

- 4.3 Зардал – үр ашгийн шинжилгээний нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох Эдийн засгийн шинжилгээг орлох биш харин нөхөх буюу дэмжих зорилгоор олон шинжүүрт шийдвэрийн (MCDA), эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний (EIA) гэх мэт аргачлалуудыг ашигладаг.
- 4.4 Хэрэв төсөл санаачлагч эдийн засгийн өгөөжийн хувь нь (EIRR) хангалттай биш төслийг хэрэгжүүлэх сонирхолтой бол зардал-үр ашгийн судалгааг орлох олон шинжүүрт шийдвэрийн шинжилгээг (multi-criteria decision analysis-MCDA) ашиглаж болно.
- 4.5 Мега төслүүдийн хувьд макро эдийн засгийн нөлөөллийг харуулах зорилготой эдийн засгийн нөлөөллийн шинжилгээг (economic impact analysis-EIA) зардал-үр ашгийн шинжилгээг дагалдах маягаар хийж болно.
- 4.6 Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг үнэлэх үзүүлэлтүүд нь салбар, дэд салбар, тухайн төслийн онцлогоос хамааран өөр өөрөөр тодорхойлогдох ба жишээ болгон боловсрол болон эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үр ашгийн зарим үзүүлэлтүүдийг Хавсралт 1-д, эдийн засгийн өгөөжийн зарим үзүүлэлтүүдийг хэрхэн тооцох аргачлалыг Хавсралт 2-т тус тус үзүүлэв.

#### **ТАВ. ЗАРДАЛ - ҮР ӨГӨӨЖИЙН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙГ ХИЙХ ДАРААЛАЛ, ҮЕ ШАТ**

- 5.1. Төслийн зардал – үр өгөөжийн шинжилгээг дараах үе шатуудаар хийнэ. Үүнд:
- 5.1.1. **Үе шат 1. Төслийг үнэлгээний шаардлага хангасан эсэхийг тогтоох.**
- Төслийн зорилго, зорилтууд салбарын тулгамдсан асуудал, бодлого, стратегийн чиглэлд нийцэх, зорилгыг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмрийг шинжлэх;
  - Төслийн тоо баримт, мэдээ, мэдээллийн бодитой, үнэ зөв эсэхийг хянах;
  - Хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртөг, зардлыг бүрэн тооцсон, санхүүгийн шинжилгээ иж бүрэн хийгдсэн эсэхийг шалгах;
- 5.1.2. **Үе шат 2. Зардал тооцох.**
- Төслийн нийт зардлыг холбогдох аргачлалын дагуу тооцоолно.
- 5.1.3. **Үе шат 3. Эдийн засгийн өгөөжийн үзүүлэлтүүдийг тооцох.**
- Төслийн үндсэн зорилгоос хамааруулан хэмжигдэхүйц, нэгэн төрлийн нэгжээр илэрхийлэгдэх боломжтой үзүүлэлтүүдийг сонгох;
  - Үзүүлэлтүүдийн утгыг тооцох;
- 5.1.4. **Үе шат 4. Эдийн засгийн засгийн өгөөжийн үнэлгээ хийх.**
- Дэд шалгуур үзүүлэлт тус бүрийн үр дүнг 3 хүртэл оноонд хөрвүүлэх;
  - Дэд үзүүлэлтүүдийн онооны нийлбэрээр үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх;
  - Төслийн эдийн засгийн үр өгөөжийн ерөнхий үнэлгээ нь эдийн засгийн үр өгөөжийн онооны арифметик дунджаар тооцогдоно;
- 5.1.5. **Үе шат 5. Эдийн засгийн өгөөжийг, түүнийг бий болгоход зарцуулсан зардалтай уялдуулан төслүүдийг эрэмбэлэх.**
- Төслүүдийг хорогдуулсан цэвэр мөнгөн зардал болон оноонд хөрвүүлсэн эдийн засгийн өгөөжөөр нь эрэмбэлж, хамгийн өндөр өгөөжийг хамгийн боломжит бага зардлаар бий болгох төслийг сонгоно.

---oOo---

*Хавсралт1. Боловсрол, эрүүл мэндийн салбарын төслийн эдийн засгийн шинжилгээнд үр ашгийн зарим үзүүлэлтүүд*

Боловсрол, эрүүл мэндийн салбарын төслүүд нь нийгмийн ашиг сонирхол, улс орны хөгжилд зориулагдсан, ашгийг үр өгөөжийн хэмжүүр болгон ашигладаггүй, төслийн үр өгөөжийн үзүүлэлтийг мөнгөжүүлэх эсвэл тоон үнэлгээнд шилжүүлэхэд төвөгтэй, ашиглалтын хугацаа олон жил үргэлжилдэг, ирээдүйд гарах зардал нь улсын төсөвт олон жилийн туршид дарамт үзүүлэх нөлөөтэй байдаг тул эдийн засгийн шинжилгээний үр дүнд үндэслэн хэрэгжүүлэх эсэх шийдвэрийг гаргах нь түгээмэл байдаг.

1. Боловсролын салбарын төслийн эдийн засгийн үр ашгийн зарим үзүүлэлтүүд:

1.1. Хувьсагчид:

- Боловсролын хөрөнгө оруулалтын өгөөж
- Төгсөгчдийн тоо
- Сургалтын орчны хүртээмж, чанар
- Нэг багшид ноогдох оюутны тооны бууралт
- Судлаач багшийн судалгааны ажлын хөрөнгө оруулалтын үр ашиг
- Нэг сурагчдад ноогдох хичээлийн талбайн хэмжээ
- Номын сангийн хангамж, хүрэлцээ
- Лабораторийн хүрэлцээ
- Бусад

1.2. Эдийн засгийн нөлөө:

- Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн голчийн өсөлт
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь
- Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд авч буй цалингийн өсөлт
- Хөдөлмөр эрхлэлтийн түвшний өсөлт
- Сурагч, оюутан, дадлагажигч ажиллагчдын насан туршид орлого олох боломжийн өсөлт
- Боловсролын түвшнээс хамааран нэмэгдэх хувь хүний орлогын өсөлт
- Боловсролтой хүн амаас нийгэмд үзүүлэх нөлөөлөл
- Бусад

2. Эрүүл мэндийн салбарын төслийн эдийн засгийн үр ашгийн зарим үзүүлэлтүүд:

2.1. Хувьсагчид:

- Нэг хүнд ноогдох эмчилгээний тоног төхөөрөмжийн хүртээмж
- Нэг эмчид ноогдох үйлчлүүлэгчдийн тоо
- Нэг өвчтөнд ноогдох эмнэлгийн талбайн хэмжээ
- Нэг хүнд ноогдох орны тоо
- Эмнэлгийн фонд ашиглалтын хувь
- Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт
- Нэг сувилагчид ноогдох үйлчлүүлэгчдийн тоо
- Өвчлөлтийг бууруулах үзүүлэлтүүд

2.2. Эдийн засгийн нөлөө:

- Үйлчлүүлэгчдийн эмчилгээний зардлын хэмнэлт
- Өвчнөөс урьдчилан сэргийлсэн хүний тооны өсөлт
- Эрүүл мэндийн амьдралын чанарын дээшлэлт
- Эрүүл мэндийн хүртээмжийн сайжралт
- Бусад

А. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төслийн зардал - үр өгөөжийн шинжилгээг хийхэд ашиглах эдийн засгийн өгөөжийн зарим үзүүлэлтүүдийг тооцох аргачлал:

- 1.1. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын түвшинд:
  - 1.1.1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:
    - А. Хамрагдалтын түвшний өсөлт: Хамран сургалтын бохир жин боловсролын салбарын хөрөнгө оруулалтын харьцаагаар тооцно. (хамран сургалтын бохир жин/төслийн хөрөнгө оруулалт)
    - Б. Нэг мэргэжлийн багшид ногдох хүүхдийн тооны бууралт: Нэг багшид ногдох хүүхдийн тооны нормоор тооцогдоно. БСШУЯ-ны сайдын 2003 оны 10 –р сарын 01-ний өдрийн 321 дугаар тушаалын хавсралт, Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон үзүүлэлтүүдийг үндэслэнэ.
    - В. Сургалтын орчин: Анги танхим, номын сангийн стандарт хангалтаар хэмжигдэнэ. БСШУЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн баримт бичиг, сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны MNS6558:2015 стандартыг үндэслэнэ.
  - 1.1.2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:
    - А. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бууруулах: Мэргэжлийн болон мэргэжлийн бус ажлын байрны тооны нэмэгдсэн байдлаар хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байрыг тооцох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.
    - Б. 100000 хүүхэд тутамд ногдох осол гэмтлийн тоог бууруулах: Осол, гэмтлээс урьдчилсан сэргийлсэн хүүхдийн тоогоор тодорхойлогдох ба осол гэмтлийн тооны бууралтын мэдээлэлд үндэслэнэ.
- 1.2. Их дээд сургууль, мэргэжлийн сургалтын түвшинд:
  - 1.2.1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:
    - А. Төвлөрлийг бууруулах: Цаг хугацааны мөнгөжүүлсэн дүнгээр тооцогдоно. Уг үзүүлэлт нь 1 цагийн хөдөлмөрийн хөлс, нийт замын түгжрэлд зарцуулсан цаг болон оюутны/багш ажилчдын тоог нэмж болно/ тооны үржвэрээр тооцогдоно. /Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр авч үзвэл 1 цагийн хөлс 2375 төгрөг; Судалгаагаар нийслэлд 1 хүн өдөрт дунджаар 2 цаг түгжирдэг; Жилд нэг хүн замын түгжрэлд 580 цаг алддаг;/
    - Б. Нэг багшид ноогдох оюутны тооны бууралт: Нэг багшид ноогдох оюутны тоогоор тооцогдох ба БСШУЯ-ны 2007 оны 74-р тушаалын хавсралт, Дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалын 2.2-д тухайн сургуульд багшийн орон тоог мэргэжлийн чиглэлийг тогтоосон харьцаанд үндэслэнэ.
    - В. Амьдрах орчны сайжралт: Дотуур байр, спорт болон ногоон байгууламжийн хангамж, хүрэлцээний нормт хэмжээгээр тодорхойлогдоно. Уг үзүүлэлтийг өмнөх нөхцөл байдлаас сайжирсан эсэхийг тодорхойлох боломжтой. БСШУЯ-ны 2007 оны 74-р тушаалын хавсралт, Дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалд сургалтын зориулалттай барилга байгууламж нь олон нийтийн иргэний барилга БНбд31-03-03" заасан байр, эрүүл ахуйн нормативд үндэслэнэ.
    - Г. Суралцах орчны сайжралт: Анги танхим, лаборатори, номын сангийн хангамж, хүрэлцээний нормт хэмжээгээр тодорхойлогдон. Уг үзүүлэлтийг өмнөх нөхцөл байдлаас сайжирсан эсэхийг тодорхойлох боломжтой. Мэргэжлийн боловсрол, сургалт, Ерөнхий шаардлага, стандарт MNS6541:2015, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартад үндэслэнэ.

1.2.2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:

А. Улс, бүс нутгийн зах зээлд нөлөөлөх нөлөөллийг нэмэгдүүлэх: Судалгааны ажлын хөрөнгө оруулалтын үр ашгийн үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Энэ нь судалгааны ажлыг зах зээлд борлуулсан орлого түүнийг гүйцэтгэхэд гаргасан зардлын харьцаагаар тооцогдоно. (судалгааны ажлын орлого/зардал)

Б. Ажил эрхлэлт нэмэгдэх: Шинээр бий болох ажлын байрны тоогоор хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байраар тооцогдох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.

В. Төгсөгчдийн орлогын өсөлт: Докторын болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр, мэргэжлийн зэргийн хөтөлбөрүүдийн тоогоор хэмжигдэнэ. Доктор, магистр, мэргэжлийн зэргийн сургалтай нөхцөлд төгсөгчдийн цалин орлогыг өсгөнө гэж үзээд, төгсөгчдийн цалинг 15 хүртэл хувиар өсгөх боломжтой гэж тооцно.

Б. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын төслийн зардал - үр өгөөжийн шинжилгээг хийхэд ашиглах эдийн засгийн өгөөжийн зарим үзүүлэлтүүдийг тооцох аргачлал:

2.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний түвшинд:

2.1.1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

А. Тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх: Нэг эмчид ногдох хэвтэн эмчлүүлэгчдийн тооны үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. 2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан MNS5095:2017 стандартын эмнэлгийн үйл ажиллагааны онцлогоос хамаарсан орон тооны норм ( 10 оронд 1 их эмч)-д үндэслэнэ.

Б. Хүн амын дундаж наслалтын нөлөөлөл: Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь, хүн амын дундаж наслалтын өсөлтийн харьцаагаар тооцогдоно. Хүн амын дундаж наслалтын өсөлтийг эрүүл мэндийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын өсөлтийн хувьд харьцуулан тооцно. (дундаж наслалтын өсөлтийн хувь/эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь)

В. Өвчлөлийн тоог бууруулах нөлөөлөл /халдварт болон халдварт бус өвчлөл/: Халдварт болон халдварт бус өвчлөлийн өсөлт, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн харьцаагаар тодорхойлогдоно. Өвчлөгчдийн түвшнээр эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын үржүүлэгч буюу халдварт ба халдварт бус өвчлөлийн өсөлтийн хувийг эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувьд харьцуулна. (өвчлөлийн тооны өсөлтийн хувь/эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь)

2.1.2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

А. Эмнэлэгт хэвтэх хүлээлтийн хугацааг бууруулах нөлөөлөл: 10 000 хүнд ногдох орны тооны өсөлтөөр хэмжигдэнэ. 10 000 хүнд ноогдох орны тоог төслийн тусламж үйлчилгээний төрлөөр статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авч өсөлтийн хувийг тооцно.

Б. Ажлын байр нэмэгдүүлэх нөлөөлөл: Шинээр нэмэгдэх ажлын байрны тоогоор хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байраар тооцогдох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.

В. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх: Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах хүний тооны өсөлтөөр хэмжигдэнэ. Эрүүл мэндийн даатгалаар 4 насны ангилалд урьдчилан сэргийлэх үзлэг хийх боломжийн тооцоонд үндэслэн эмнэлгийн үйлчилгээний шатлалаар үнэлнэ. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 09 сарын 28-ний өдрийн 19 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад заасан урьдчилан сэргийлэх үзлэгийн багцыг харгалзан үзэх.

2.2. Эм ханган нийлүүлэлтийн түвшинд:

2.2.1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

А. Эм, ханган нийлүүлэлтийн хангамжийн эрсдэлийг бууруулах: Эм ханган нийлүүлэлтийн зайлшгүй байх нөөцийн хэмжээний үзүүлэлтээр хэмжигдэх ба Монгол улсын эмийн бүртгэлийн зайлшгүй шаардлагатай жагсаалтад орсон эмийн эзлэх хувийн жинг үндэслэн тооцно.

Б. Хүн амын эрүүл мэндэд эмийн чанарын үзүүлэх нөлөөлөл: Гаж нөлөөгүй эмийн тоо, хэмжээ стандартын шаардлагыг харгалзан үзнэ. MNS5524-1:2014 эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлагыг заалтуудыг бүрэн хангасан байхад үндэслэнэ.

В. Импортын оруулалтын нөлөөлөл: Эмийн импортын хэмжээгээр хэмжигдэх ба эм зүйн салбарын статистикаас Монгол улсад импортолсон бүтээгдэхүүний нэр төрлийн дэлгэрэнгүй судалгаанд үндэслэн үнэлнэ.

2.2.2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

А. Үнийн хөнгөлөлт: Үнийн хөнгөлөлтийн хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ тогтоосон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолд үндэслэнэ.

Б. Ажлын байр нэмэгдэх нөлөөлөл: Шинээр нэмэгдэх ажлын байрны тоогоор хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байраар тооцогдох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.

В. Төсвийн орлогын нөлөөлөл: Татварын хэмжээний нэгжийн өсөлтийн төсвийн орлогын өөрчлөлтийн харьцаагаар тодорхойлогдоно. Улсын төсвийн орлогын өөрчлөлтийн хувийг төслийн тооцоогоор татварын хэмжээнд харьцуулах, ҮСХ-ны мэдээлэл, төслийн хүчин чадлын мэдээлэлд үндэслэнэ.